



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/144

Мөрөн сум

Хүүхдийн төлөө зөвлөлийн
бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах шаардлагатай арга хэмжээ авах чиг үүрэг бүхий аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн байгуулсугай.

2. Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах төрийн бодлого, хууль тогтоомж, орон нутгийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг тогтвортой ханган, хүүхдийн асуудлаарх салбар дундын оролцоо, хамтын ажиллагааг тууштай хэрэгжүүлж, үр дүнтэй хамтран ажиллахыг зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/135 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.


4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2023 оны 04
дүгээр сарын 11-ний өдрийн А/144
дугаар захирамжийн хавсралт



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Гишүүдэд:

- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (зөвшилцсөнөөр)
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
- Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
- Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга
- Аймгийн Цагдаагийн газрын дарга
- Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
- Аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга
- Аймгийн Онцгой байдлын газрын дарга
- Аймгийн Соёл, урлагийн газрын дарга
- Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
- Аймгийн Статистикийн хэлтсийн дарга
- Орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагын төлөөлөл-1 (зөвшилцсөнөөр)
- Аймгийн Хүүхдийн элч
- Аймгийн Хүүхдийн зөвлөлийн тэргүүн
- Аймгийн Хүүхдийн зөвлөлийн дэд тэргүүн
- Аймгийн Хүүхдийн зөвлөлийн нарийн бичиг
- Төрийн бус байгууллагын төлөөлөл-1
- Иргэдийн төлөөлөл-1

Нарийн бичгийн дарга:

- Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Гэр бүл, хүүхэд, залуучууд, жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн.

___оОо___